



**ГОВЬСҮМБЭР АЙМАГ  
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ**

2022 оны 02 сарын 24 өдөр

Дугаар 8/18

Шивээговь сум

Г  
**Б.Мөнхцэцэгтэй байгуулсан хөдөлмөрийн  
гэрээг дуусгавар болгох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Захиргааны өрөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Хөдөлмөрийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.1.4, Төрийн албаны зөвлөлийн 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн “Албан тушаалын сул орон тоог нөхөх зарим арга хэмжээний тухай” 411 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Төрийн албаны зөвлөлийн Говьсүмбэр аймаг дахь салбар зөвлөлөөс “Төрийн жинхэнэ албаны нөөцөд бүртгэлгүй, сонгон шалгаруулалтгүйгээр Төрийн албаны тухай хууль, албан тушаалын тодорхойлолтод заасан тусгай шаардлагыг хангагүй, гэрээгээр томилогдсон албан хаагчдыг чөлөөлөх тухай” чиглэл ирсний дагуу Хүнс, жижиг дунд үйлдвэр, хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэн Базарын Мөнхцэцэгтэй байгуулсан хөдөлмөрийн гэрээг 2022 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс дуусгавар болгосугай.

2. Б.Мөнхцэцэгийн хариуцаж байсан ажлыг хүлээлцүүлэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай.

Комиссын дарга:

Д.Отгонбаатар

(Мал аж ахуйн үйлдвэрлэлийн төлөвлөлт, менежмент, малын үржил, бүртгэлийн асуудал хариуцсан мэргэжилтэн)

Гишүүд:

Б.Ууганбаяр

(Архив, бичиг хэргийн эрхлэгч)


Д.Гантоотох

(Нярав)

3. Ажлыг хугацаанд нь зохион байгуулж, биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг комиссын дарга (Д.ОТГОНБААТАР)-т даалгасугай.

ДАРГА

Д.ОТГОНЖАРГАЛ



422220068